



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 04 сарын 28 өдөр

Дугаар А/137

Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Ховд" нисэх буудлын хөөрч буух хучилттай зурвас, агаарын хөлгийн зогсоолын их засвар /Ховд, Ховд сум/-ын ажлыг хийж гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай. Үүнд:

Үнэлгээний хорооны
дарга:

Б.Ганхуяг
(Агаарын навигаци, нисэх буудлын бодлого
зохицуулалтын газрын менежер)

Гишүүд:

Д.Цогням
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Нисэх буудлуудын
үйлчилгээний газрын менежер)

А.Энхцэцэг
(“Үндэсний аж үйлдвэрлэлийн зөвлөл” Төрийн бус
байгууллагын гишүүн (тохиролцсоноор))

О.Баярсайхан
(“Сэтгэл зүй судалгаа, мэдээллийн төв” Төрийн бус
байгууллагын гишүүн (тохиролцсоноор))

Нарийн бичгийн
дарга:

Б.Сумъяажав
(Иргэний нисэхийн үндэсний төвийн Хөрөнгө оруулалт,
захиалагчийн албаны Худалдан авах ажиллагааны
тасгийн мэргэжилтэн)

2.Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг хууль тогтоомжийн дагуу зохион байгуулахыг үнэлгээний хороо (Б.Ганхуяг)-нд, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (Т.Батжаргал), Иргэний нисэхийн үндэсний төв (Н.Батсайхан)-д тус тус үүрэг болгосугай.

3.Тендер болон сонгон шалгаруулалттай холбоотой баримт бичгээр архивын нэгж бүрдүүлж, холбогдох албан тушаалтанд хүлээлгэн өгөх, тендерт оролцоход үнэлгээний хорооны гишүүдээс ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдлийг гаргуулан Дотоод аудитын албанд хүргүүлэхийг үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Сумъяажав)-д даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА